

**ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР  
НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 10 дугаар  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүл ахуйн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх тухай асуудлыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд хүний эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах, суралцах, ажиллах нөхцөлийг хангах талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажлыг тодорхой болгох, төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн шаардлагад нийцуулэх, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн хяналтыг өргөжүүлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд эрүүл ахуйн тандалт, судалгааг зохион байгуулах тухай асуудлыг тусгасан байна.

Уг хуулийн төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Е.Отгонбаяр, Ц.Оюунгэрэл, Д.Сарангэрэл, Д.Хаянхярваа нар төслийн ерөнхий үзэл санаа зөв хэдий ч боловсруулалт хангалтгүй, тухайлбал агаарын бохирдол, төв цэвэрлэх байгууламж, орчны тоосжилт, хог хаягдал, мал бүхий иргэдийн суурьшлын бус, төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийн стандартад тавих шаардлага зэрэг асуудлыг тодорхой болгох, төрийн захиргааны төв байгууллагын хүлээх үүрэг, эрүүл ахуйн тухай мэдлэгийг иргэдэд олгох асуудлыг нэмж тусгах нь зүйтэй гэсэн саналыг гаргасан болно.

Эрүүл ахуйн тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүл ахуйн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар тус Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**

**Д.БАТЦОГТ**

